



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/69

Жаргалтхаан сум

**Гэрээ байгуулж, санхүүжилтийн
эрх олгох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 28 дугаар зүйлийн 28.1.1, 34 дүгээр зүйлийн 34.9, 45 дугаар зүйлийн 45.5, 48 дүгээр зүйлийн 48.2.6 дахь заалтууд, заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 178,083,883 (нэг зуун далан найман сая наян гурван мянга найман зуун наян гурав) төгрөгийн хөрөнгөөр хийгдэх “Хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулах” ажлын гэрээг “ОДЖИ ОД” ХХК-тай байгуулж санхүүжүүлэх эрх олгосугай.

2.Ажлын гүйцэтгэлийг харгалзан санхүүжилтийг олгохоор гэрээ байгуулан батлуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэн тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Мөнхдэлгэр)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ